

Цагийн хуваарь шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, 23 дугаар зүйлийн 23.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.11, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Завхан Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарыг нэгдүгээр, аймгийн нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх цагийн хязгаарыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газруудын цагийн хязгаарыг мөрдүүлж, тогтмол хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Э.Балжинням), Цагдаагийн газар (Н.Отгонжаргал), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийг холбогдох хууль, журмын дагуу Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх, зохион байгуулалтын арга хэмжээ авч, захирамжийг хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (У.Батдаваа)-д даалгасугай.

4.Захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2019 оны 10 дугаар 01-ний өдрийн А/291 дүгээр, 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн А/245 дугаар, Улиастай сумын Засаг даргын 2020 оны 10 дугаар сарын 21-ны өдрийн А/349 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Г.ӨНӨРБАЯР

Аймгийн Засаг даргын 2024 оны дүгээр сарын
.....-ны өдрийн дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Аймгийн хэмжээнд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаар

№	Худалдаа, үйлчилгээний төрөл	Тусгай зөвшөөрлийн ангилал	Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаар	
			Эхлэх	Дуусах
1	Хүнсний бөөний болон жижиглэн худалдаа	Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй	08:00	00:00
2	Ая тухтай дэлгүүр	Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй, үйлчилгээний зориулалтын байртай (нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөл хамаарахгүй)	24 цагаар	
		Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөлтэй, нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөлд байрлалтай	08:00	00:00
3	Жуулчны бааз, амралтын газар, зочид буудлын дэргэдэх ресторан, баар, кафе	11:00-22:00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	11:00	22:00
		14:00-04:00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	14:00	04:00
4	Ресторан, кафе	11:00-22:00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй	11:00	22:00
		14:00-04:00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, үйлчилгээний зориулалтын байртай (нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөл хамаарахгүй)	14:00	04:00

5	Баар	14:00-04:00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй, үйлчилгээний зориулалтын байртай (нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөл хамаарахгүй)	14:00	04:00
---	------	--	-------	-------

Аймгийн Засаг даргын 2024 оны дүгээр сарын
.....-ны өдрийн дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

Аймгийн нутаг дэвсгэрт үйлчилгээ эрхлэх цагийн хуваарь

№	Худалдаа, үйлчилгээний төрөл		Үйл ажиллагаа нээх	Үйл ажиллагаа хаах
1	Хүнсний зах, худалдааны төв		08:00	22:00
2	Хүнсний бус барааны зах, худалдааны төв		08:00	22:00
3	Хүнсний бөөний худалдаа		08:00	22:00
4	Хүнсний жижиглэн худалдаа	Үйлчилгээний зориулалтын байртай (нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөл хамаарахгүй)	08:00	00:00
		Нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөлд байрлалтай	08:00	00:00
5	Ая тухтай дэлгүүр	Үйлчилгээний зориулалтын байртай (нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөл хамаарахгүй)	06:00	00:00
		Нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөлд байрлалтай	06:00	00:00
6	Хүнсний мухлаг		06:00	00:00
7	Хүнсний бус барааны дэлгүүр		08:00	23:00
8	Түргэн хоолны газар	Үйлчилгээний зориулалтын байртай (нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөл хамаарахгүй)	08:00	21:00

		Нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөлд байрлалтай	08:00	18:00
9	Нийтийн үйлчилгээтэй цайны газар, кофе шоп	Үйлчилгээний зориулалтын байртай (нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөл хамаарахгүй)	08:00	21:00
		Нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөлд байрлалтай	09:00	20:00
10	Ахуйн үйлчилгээний цэг салбарууд (үсчин, гоо сайхан, халуун ус, хивс угаалга,)	Үйлчилгээний зориулалтын байртай (нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөл хамаарахгүй)	08:00	23:00
		Нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөлд байрлалтай	08:00	22:00
11	Авто засвар, үйлчилгээ		08:00	00:00
12	Чийрэгжүүлэх, бялдаржуулах үйлчилгээ		06:00	22:00
13	Цахим тоглоомын газар	Үйлчилгээний зориулалтын байртай.	09:00	18:00
		Нийтийн зориулалттай орон сууц, түүний өргөтгөлд байрлалтай	15:00	18:00
14	Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээ		09:00	20:00